



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗАР



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2017 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "ГИХГ" гэх/ болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /цаашид "ГБХЗХГ" гэх/ хамтад нь "талууд" гэх Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргаж эрх тэгш, ил тод, шударга, харилцан хүндэтгэлтэй байх зарчмыг үндэслэн дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү Санамж бичгийг байгуулав.

Хоёр.Хамтын ажиллагааны зорилго

2.1.Энэхүү хамтын ажиллагааны зорилго нь Монгол Улс Хүүхдийн эрх, Гэр бүлийн асуудлаарх Олон Улсын гэрээ, Конвенцээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хүрээнд бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

Гурав.Байгууллага хоорондын хамтын ажиллагааны чиглэл

3.1. Талууд дараах үйл ажиллагаанд хамтран ажиллана:

3.1.1. Гэр бүлийн хөгжлийг дэмжих болон хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний бүтээлч сэтгэхүйг нь хөгжүүлэх, амьдрах ухааны эерэг хандлага, дадал чадвар эзэмшүүлэн нийгэмшүүлэхэд анхаарч ажиллахад тусламж, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

3.1.2. Талууд төрийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд харилцан мэдээлэл солилцож, хамтран дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.1.3. Гадаадын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдэд үрчлэлтийн дараах хяналтыг тавихад хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох.

Дөрөв.Талуудын эрх, үүрэг

4.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь:

4.1.1. ГИХГ-ын албан хаагчдын гэр бүл, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх;

4.1.2. ГИХГ-ын албан хаагчдын хүүхдийг олон улсын хүүхдийн Найрамдал зусланд хөнгөлөлттэй үнээр амруулах;

4.1.3. Монгол Улсад гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны стандарт нөхцөлийн талаар ГИХГ-т мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;

4.2. Гадаадын иргэн, харьяатын газар нь:

4.2.1. ГБХЗХГ-аас зохион байгуулж буй олон улсын чанартай арга хэмжээнд оролцох, гадаадын төлөөлөгчдийг Монгол Улсад ирэх тал дээр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;

4.2.2. ГБХЗХГ-ын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгслээр дэмжлэг үзүүлэх;

4.2.3. Монгол Улсад гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын талаарх мэдээллийг ГБХЗХГ-т өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

4.3.Талууд хамтран:

4.3.1. Орогнол хүсэгч, дүрвэгч, цагаач хүмүүсийн хүүхдүүдийг хамгаалж халамжлах, тэдэнд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бүх төрлийн арга хэмжээг авах;

4.3.2 Монгол Улсаас гадаад улсад үрчлэгдэх, үрчлэгдсэн хүүхдийн эрхийн хяналтыг сайжруулж эх орон, ах дүү, хамаатан садантайгаа холбоотой байх, үндэсний өв соёлоо уламжлах бүх талын боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

4.3.3.Монгол Улсад байгаа гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн хүүхэд, орогнол хүсэгч, дүрвэгч, цагаач хүүхдийн талаарх бүх төрлийн мэдээллийг бүрдүүлж нарийвчилсан мэдээллийн санг үүсгэн хөгжүүлэх;

4.3.4. Монгол улсад түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаад хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах,

4.3.5.Хамтын ажиллагааны хүрээнд мэдээлэл, баримт бичгийг харилцан солилцох, бусад харилцан сонирхсон асуудлаар яриа хэлэлцээ хийх,

4.3.6.Холбогдох асуудлаар байгууллага, иргэн, хувь хүнд зөвлөмж боловсруулах, түүнчлэн шаардлагатай тохиолдолд хамтарсан төлөвлөгөө, хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулах,

4.3.7.Холбогдох асуудлын динамик өөрчлөлтийн талаар статистик мэдээг солилцох

4.3.8 Харилцан сонирхож буй бусад чиглэл.

Тав. Бусад

5.1.Талууд энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг хамтын ажиллагааны төлөвлөгөөг жил бүрээр боловсруулан хоёр талын удирдлага баталж, байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгана.

5.2.Ажлын хэсгийн ахлагч нар жилд нэгээс доошгүй удаа уулзаж төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэх бөгөөд цаг үеийн шинжтэй асуудлаар тухай бүр биечлэн уулзаж болно.

5.3.Ажлын хэсгийн хуралдааны тов, газар, хэлэлцэх асуудлыг ажлын хэсгийн ахлагч нар тодорхойлно. Хурлын тэмдэглэлийг тухай бүр аудио хэлбэрээр хуулж, тэмдэглэлийг ажлын 10 хоногийн дотор бичин хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулан хадгална.

5.4.Талууд Санамж бичгийн хүрээнд гүйцэтгэж буй ажилтай холбоотой аливаа асуудал, маргаан, үл ойлголцлыг хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцлийг эрхэмлэн хэлэлцээний зарчмаар шийдвэрлэж байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА


Д.МӨРӨН
2017 оны 06-р сарын 22-ны өдөр

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА


О.АЛТАНСҮХ
2017 оны 06-р сарын 22-ны өдөр